

МАНМИН МЭДЭЭ

№ 82 2020 оны 3 сарын 22

И Жей руг пасторын ном 58н орны хэлээр цахим хэлбэрээр нийтлэгдэн

Амазон зэрэг интернэт номын дэлгүүрүүдээр
Солонгос болон гадаад түгээгдсээр



“Загалмай үг”, “Итгэлийн хэмжээ”, “Тэнгэрийн орон” зэрэг И Жей руг пасторын хэвлэгдсэн ном, мөн цахим хэлбэрээр дэлхий даяар эрэлттэй түгээгдсээр ирэв.

И Жей руг пасторын ном нь нийт гадаадын 62орны хэлээр 639төрлийн (Солонгос 112төрөл, гадаад хэл 527төрөл) хэвлэгдэн гарсан бөгөөд Англи, Хятад, Испани, Орос, Араб, Еврей зэрэг 58орны хэл 55төрлийн хэвлэгдэн болон цахим хэлбэрээр гарсан байна.

Саяхан цахимаар “Итгэдэг

зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа” чех болон эстони хэл дээр гарч, “Сэр Израйль” румын хэл хэл дээр “Бурханы хууль” Руанда ба чех хэл дээр “Хараагдсан амьдрал ба дуулгаварт амьдрал” итали хэл дээр бэлтгэгдэн гарлаа.

И Жей руг пасторын цахим ном нь дэлхийнхамгийн том онлайн номын дэлгүүр болох Амазон, iBookstore, Гүүглэ бүүкс төдийгүй солонгосын Кёобу мунгү, Риди бүүкс, Интерпак зэрэг онлайн номын дэлгүүрүүдээр

авах боломжтой бөгөөд уншигчдын тоо нэмэгдсээр байна.

Түүнчлэн И Жей руг пасторын итгэлийн амьдарлын тухай номууд нь маш их мацаг барилт болон залбирлаар Бурханы үгийг тайлсан амийн үг агуулагдсан байгаа юм.

Дэлхий даяарх үй олон номлогч нар ба итгэгч нарт сүнс талын гарын авлага болж үүгээр дамжуулан итгэлээр өсч, өөрчлөгдөж амьдрал нь шинэчлэгдэн Бурханы ивээлийг авч байна.



Tel: 82-2-824-7107
www.gcntv.org
webmaster@gcntv.org



Tel: 82-2-818-7334
www.manminseminary.org
manminseminary2004@gmail.com



Tel: 82-2-818-7039
www.wcdn.org
wcdnkorea@gmail.com



Tel: 82-70-8240-2075
www.urimbooks.com
urimbook@hotmail.com

2020онд ерөөл их аваарай, бид Манминыг дэмжиж байна.



Андрей Газировски доктор
(Израиль Холокост амьд үлдэгсдийн холбооны захирал)

Би болон манай гэр бүлийнхэн ээдрээтэй цагуудыг өнгөрөөж буй Манмин төв цуглааны төлөө залбирч байна.

Мөн И Жей руг пасторын залбирлаар манай эхнэр Буженагын нуруу болон аарцагны асуудал И Сү жин пасторын залбирлаар манай бэр Сарагын хөхний хорт хавдар эдгэрсэн тухай үргэлж талархаж байна. Бид үргэлж дэмжиж байгаа бидний хайрыг дамжуулж байна.



Марк Бажалеп пастор
(АНУ, Ворлд сайн мэдээний төв)

Шинэ оны босгон дээр АНУ Ворлд сайн мэдээний төвөөс мэндчилж байна. Үргэлж залбирал ба хайраар хамт байж өгсөнд баярлалаа.

Би И Жей руг докторын ариун сайн мэдээг зөвшөөрч өгсөн Бурханы агуу зорилго ба алсын хараанд итгэж байна. Мөн И Жей руг докторын даруу төрх болон золиос гаргаж буй байдлыг үргэлж санан залбирч байна. Бид баяр хөөртэй байхад нь ч хүнд хэцүү үед ч үргэлж Манминтай хамт байх болно.



Александр Самунуф пастор
(ОХУ, Калининград бүсийн ерөнхий удирдагч)

2020он шинэ оныг угтан мэндчилж байна. Манмины туулж буй сорилтын үйл явцын төлөө бид ч хамтдаа залбирч байгаа ба итгэл болон итгэмжтэй байдлаар ялан дийлэх Манминыг бид дэмжиж байна.



Ара Кучяно пастор
(Армения Христийн гэр бүл цуглаан)

Эрхэм хүндэт Манмины итгэгч нараа, шинэ ондоо ивээл ерөөл их аваарай. Юуны өмнө Манмины эрхэм нандин үйлчлэлд талархаж байна.

Бид Бурханд итгэдэг, Бурханы эрм мэдэлт хүчийг биелүүлж буй Манмины үйлчлэлийг дэмжиж байна. 2020онд хүнд цаг үеэ ялан дийлж, маш их үр жимс гаргахыг хүсье.

‘Сүнслэг хайр’ цуврал 12

Үнэнтэй хамт баярладаг хайр

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөвт бус байдалд баярладаггүй.” 1 Коринт 13:4-6

И Жей руг тэргүүн пастор

Есүсийн арван хоёр шавийн нэг болох элч Иохан бол бусад шавь нар шиг амиа зориулалгүй Есүс Христийн гэрчлэлийг хүлээн авч сайн мэдээний нууц болон Бурханы хүслийг ихээр дамжуулсан юм.

Амьдралынхаа сүүлчийн жилүүдэд түүний маш их баярлаж байсан зүйлүүдийн нэг нь итгэгч нар Бурханы үгийг мөн үнэний үгийн дагуу амьдрахын төлөө хичээж байгаа явдал байлаа. Үүнээс илүү их баяртай зүйл үгүй гэж тэрээр өөрийн гэрчлэлийг (3 Иохан 1:3-4)-с түүний баяр хөөрийг ямар байсныг мэдэх боломжтой юм. Аяндын хүү гэж нэрлэгдэх хэмжээний огцом ууртай байсан тэрээр өөрчлөгдөж хайр элч гэж нэрлэгдэх болсоныг үүнээс харах боломжтой юм.

Энэ мэт сүнслэг хайрыг бий болговол ёс бусыг үйлдэхгүй байх төдийгүй үнэнийг хичээнгүйлэн хийдэг болдог. Цаашлан үнэнтэй хамт баярладаг болохыг харж болно. Хайр бол үнэнтэй хамт баярлах чухал илэрхийлэмж юм.

Үнэн бол Есүс Христийг хэлж байгаа бөгөөд мөн сайн мэдээг илэрхийлж, библийн бнбонд Бурханы үгийг хэлдэг. Бурханы хайрлаж, Бурханы хайрыг хүртсэн хүн бол Есүс Христтэй хамт баярлаж, сайн мэдээний үйлсэд баярлахаас өөр аргагүй юм. Бурханы хаанчлал өргөжихөд мөн баяртай байдаг.

Тэгвэл сүнслэг хайрын 15н хэсгийн нэг болох ‘Үнэнтэй хамт баярлах’ гэдгийн гүн утга нь юу вэ?

1. Есүс Хрситийн сайн мэдээнд баярладаг.

Хэн ч гэсэн Есүс Христэд итгэвэл аврал авч, тэнгэрийн орон руу орно гэх ерөөлтэй мэдээ нь сайн мэдээний гол цөм нь юм.

Газар сайгүй хэзээ ямагт олон хүмүүс үнэнийг хайсаар ирсэн. ‘Амьдралын жинхэнэ утга учир юу вэ?’ ‘Үнэ цэнэтэй амьдрал хаана байна?’ гэсэн асуултын хариултыг олохын төлөө үзэл баримтлал, гүн ухаанийг шинжлэн судлаж, төрөл бүрийн шашны үзэл баримтлалаар үнэнийг эрэн хайдаг.

Тэгвэл Есүс үнэний уг үндэс бөгөөд хэн ч Есүсээр дамжихгүйгээр тэнгэрийн орон руу орж чадахгүй юм. Иохан 14:6д “Би бол зам үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” гэсний дагуу зөвхөн Есүс Христ л авралын зам юм.

Есүс Христийн үнэт цусаар гэмээс уучлагдаж байж мөнх амийг авч, тэнгэрийн орон руу орох боломжтой. Ийм амьдралын зорилгыг ухаарч жинхэнэ үнэ цэнэтэй амьдарвал сайн мэдээнд баярлана гэдэг нь мэдээжийн зүйл юм. Сайн мэдээнд баярладаг хүн хичээнгүйлэн сайн мэдээг түгээдэг. Өгөгдсөн үүрэг албаа ч сайн гүйцэтгэхийн төлөө зүтгэдэг. Мөн Бурханы хүслийг мэддэг тул сайн мэдээг сонсч, Эзэнийг хүлээн авч, аврал авсан хүмүүс олширч байгаад баярладаг (1 Тимот 2:4).

Зарим хүн өөр хүн сайн мэдээг тараагаад олон үр жимстэй болвол атаархаж, хорсдог. Бусад цуглаанууд сэргэвэл Бурханд алдрыг өргөвөл

атаархдаг сүм бас байна. Ийм сэтгэл бол үнэнтэй хамт баярлах сэтгэл биш юм.

Сүнслэг хайр байгаа бол Бурханы хаанчлал агуу ихээр биелэгдэж байгаад баярладаг. Надаас илүү хичээж зүтгэж байгаа хүнийг хараад баярлаж, талархдаг. Сэргэж, хайрлагдаж буй сүм цуглааныг харахад хамтдаа баярладаг. Энэ бол сайн мэдээнд баярлах сэтгэл, хайрын сэтгэл юм.

2. Үнэнд хамаарах бүх зүйлд баярладаг.

Библид гардаг сайны сэтгэл, хайр, шударга байдал нь үнэнд хамаарах зүйлсийг харж, сонсож үйлдэхэд нь баярлахыг хэлж байгаа юм.

Үнэнтэй хамт баярладаг хүн нь жижигхэн сайн үйлсэд ч баярлан сэтгэл хөдөлдөг. Үнэн болох Бурханы үг зөгийн балаас ч илүү амтлаг гэж үргэлж сургаал сонсож, библи судлан унших явдлыг баяртайгаар хийдэг. Цаашлан Бурханы үгийн дагуу үйлдэхдээ баяртай байдаг. Хэдийгээр хилсээр хохирол учруулсан хүн байсан ч Бурханы үгэнд “Үйлчилж өг, ойлгож уучил” гэдэг тул тэрчлэн дуулгавартай дагадаг.

Давид бол Бурханыг хайрладаг учраас Бурханы өргөөг барихыг хүсч байсан ч Бурхан түүнийг нь зөвшөөрөөгүй юм. Түүний учир нь тэр дайчин хүн байсан тул цус их урсгасан гэсэн байдаг (Шастирын дээд 28:3). Дайны талбарт тэрээр яах ч аргагүй нөхцөлд цус урсгаж байсан түүнийг Бурханы өргөөг барих нь зохисгүй гэж үзсэн юм.

Хэдийгээр өөрийн гараар Бурханы өргөөг барьж чадаагүй ч тухайн үед хаанчилж байсан хүү Соломоноор дамжуулан Бурханы өргөөг барихад нь дэмжиж төрөл бүрийн барилгын материалыг бэлдсэн байв. Давид нь ард түмэнтэйгээ хамт Бурханд өргөөнд хэрэглэгдэх эд материалуудыг бэлдэж байхдаа тэсэхийн аргагүй туйлын их баяр хөөртэй байсныг харж болох юм (Шастирын дээд 29:9).

Энэ мэт хамт баярладаг хүн бусад нь амжилтанд хүрвэл хамтдаа баярладаг. Атаа хорсол, ‘Бүтэлгүйтээсэй...’ гэж бодлыг төсөөлж ч чаддаггүй юм. Ёс бус байдал гарвал гашуудан харамсдаг.

Мөн үнэнтэй хамт баярладаг хүн хувируулах сэтгэл, үнэнч, шударга зэрэг сайны сэтгэлд дуртай байдаг. Сайны үг хэл, болон үйлдэлд баярладаг. Ийм хүүхдүүдээ харахад Бурхан туйлын ихээр баярлан хөөрдөг (Зефаниа 3:17).

Харин өөрийгөө үнэнтэй хамт баярлаж чадахгүй дүр төрх жоохон үлдсэн байлаа гээд сэтгэлээр унах хэрэггүй юм. Хайрын Бурхан тэр хүнийг ингэж хичээж буй төдийг ч үнэнтэй хамт баярлаж байна гэж хүлээн авдаг.

3. Бурханы үгэнд итгэж, тэр чигээр нь үйлдэж хичээдэг.

Анхнаасаа үнэнд л баярладаг хүнийг хайж олоход амар биш юм. Сэтгэлд нь харанхуй болон худлын сэтгэл байх үед хорон мууг бодох юм уу, ёс бус зүйлд баярладаг. Тэгмэгцээ бага багаар өөрчлөгдөн худлын сэтгэлийг бүрэн хаяж, үнэнд л баярладаг сэтгэлтэй болдог. Тийм болох хүртлээ маш шаргуу хичээх явц хэрэгтэйг харж болох юм.

Жишээ нь дандаа аз жаргалтай мөргөлд оролцдог хүмүүс гэж байхгүй. Анх ирээд удаагүй итгэгч юу нь яах

ёстойг сайн мэдэхгүй учир ядрах юм уу, бодол санаа нь өөр газар байх үе ч байх үе ч бий. Гэхдээ Бурханы өргөөнд ирж мөргөлд оролцож буй үйлдэл нь үнэний үгийн дагуу дуулгавартай дагаж байгаа хэлбэр юм. Энэ нь үнэнтэй хамт баярлаж, аврал хүртэж тэнгэрийн орон руу явахын төлөө юм.

Эцэст нь үнэн болох Бурханы үгийг сонсч, Бурханд итгэдэг учир Тэнгэрийн орон, там байгаа гэдэгт ч мөн итгэдэг. Хүн тус бүрт өгөгдсөн тэнгэрийн орны шагнал өөр өөр байдлыг мэдэх тул хичээнгүйлэн ариун байдлыг олж итгэмжтэйгээр зүтгэх хэрэгтэй юм. Энэ мэт зуун хувь үнэнтэй хамт баярлахгүй байсан ч хүн болгоны итгэлийн хэмжээний дагуу бүх хүчээ зориулна гэдэг нь үнэнтэй хамт баярлах үйлс юм.

4. Үнэний төлөө цангах.

Үнэнтэй хамт баярлана гэдэг нь зөвхөн үнэн л биднийг өөрчилж чадах учраас тэр юм. Өөрөөр хэлбэл сайн мэдээг сонсоод итгэж тэр үгийн дагуу амьдарч мөнх амийг олж, төгс Бурханы хүүхэд болон өөрчлөгддөг. Тэнгэрийн орны тэмүүлэл ба сүнслэг хайраар дүүрэн байч учраас нүүр царай ч баяр хөөрөөр гэрэлтдэг. Мөн үнэнээр өөрчлөгдөх тусам Бурхан болон хүмүүсээс хайрыг авах тул маш их баяр хөөртэй юм.

Тиймээс үнэнтэй хамт баярлахын хамт түүнийг эрэлхийлж байнга цангах явдал юм. Бид өлсөж цангавал идэх хоол, уух зүйл бодогддог шиг үнэнийг хайх сэтгэл ч тийм байж маш хурдан өөрчлөгдөх боломжтой юм. Сүнслэг хайр их байх тусам үргэлж үнэнээр хооллож, ундаалж амьдардаг.

Үнэнийг хооллож, ундаална гэдэг нь Бурханы үгийг хичээнгүйлэн судлан өөрийн тэжээл болгон үйлдэхийг хэлж байгаа юм. Библид амьдралын

хүнд хэцүү асуудлыг шийдэх арга болон ерөөгдөх болзол, аврал ба мөнх амьдралын замыг зааж өгсөн эрдэнэсийн сан учраас Бурханы үгтэй ойрхон байж, үйлдэх үед ерөөл дагалддаг.

Хайртай хүнийнхээ хажууд байвал нүүр царай баяслаа нуух хэцүү байдаг. Үүний нэгэн адил яг одоо бид Бурхантай нүүр тулан уулзаж чадахгүй ч Бурханыг чин сэтгэлээсээ хайрлавал заавал тэмдэг ирдэг. Үнэнийг харж, сонсоход л баярлаж аз жаргалтай байхад л “Их аз жаргалтай байхнээ” гэсэн үгийг сонсдог.

Мөн Бурхан болон Эзэнийг л бодоход талархалын нулимс гарч, жижигхэн сайн үйлсийг хараад ч сэтгэл хөдлөн нулимс урсаж байна. Үүнчлэн итгэлээр амьдарч, урсгасан талархалын нулимс, хүмүүсийн төлөөх гашуудлын нулимс зэрэг сайхан сэтгэлд хамаарах нулимс нь хожим үзэсгэлэнт эрдэнэс болон хүн тус бүрийн мөнхийн тэнгэрийн орон дахь гэрийн чимэглэл болдог.

Хайрт итгэгч та бүхэн, Үзэсгэлэнтэй сүнслэг хайрыг бий болгон үнэнтэй хамт баярлан, Бурханы хайрыг хүртсэн баталгаа та бүхний амьдралд бялхам дүүрэн байхыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
<http://www.manmin.org/english>
www.manminnews.com
e-mail: manminninen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмгэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



27н жилийн хувиршгүй үйлчлэл

“Үйлчлэлийн баяр хөөрөөр Эзэний өдөр илүү аз жаргалтай.”

Манай сүмд итгэгч нартаа үйлчлэхийн тулд цугласан 'Манмин үйлчлэлийн хороо' байдаг. Сүмийн төрөл бүрийн үйл ажиллагаа, сүмийн ойролцоо авто замын зохицуулга, зогсоолын зохицуулга, тэргэнцэртэй итгэгч нарыг зөөх үйлчлэгчид, сүмийн цэвэрлэгээ, Мөргөлийн мэдээлэлийн номын үйлчлэл, Эзэний өдрийн хоолны үйлчлэл, болон аяга тавга угаах гэх зэргээр үйлчилж байна. Эдгээр хүмүүс 27н жилийн турш нэг сэтгэлээр зүтгэж, өнгөрсөн 2-р сард '2019оны шилдэг ажилчин'-р шалгарсан И Чүн ү сүмд үйлчлэгч (1-р их бүлэг 3-р хэсэг) гэрчлэлийг танилцуулъя.



Амийн сургаалиар ивээл авч эрх хүчит залбирлаар охины атопи арьсны үрэвслээс эдгэрсэн

Би энэ сүмд ирж бүртгүүлээд, И Жей руг тэргүүн пасторын сургаалийн сонссон 'Яг энэ л үнэн байна. Ийм л сургаалиар жинхэнэ итгэлээр амьдарч болох нь' гэж мэдрэгдсэн юм. Юу нь гэм нүгэл болох хэрхэн хаях талаар Бурханы хүслийг маш тодорхой заасан юм.

Үүнээс хойш эхнэртэй баяр хөөртэй сүмд явж байхад миний охин атопи гэх арьсны халдварт өвчнөө өвдсөн юм. Тэгээд тэргүүн пасторын залбирлыг хоёр ч удаа авч, эмнэлэг явж ямар эмчилгээ хийлгээгүй ч маш цэвэрхэн эдгэрсэн юм.

Охиноороо дамжуулан Бурханы эрх мэдэлт хүчийг мэдрч, би ч Ариун сүнсээр

бялхаж 'Сүмийнхээ төлөө би юу хийх билээ' гэж хайж байв. Тэгээд Манмин үйлчлэлийн холбоонд нэгдэж, тэрнээс хойш 27жил замын зохицуулга хийсээр ирлээ.

Үргэлж 'Эзэн энэ үед яах байсан бол' бодон үүргээ гүйцэтгэхэд баяр хөөр ба аз жаргалаар дүүрч

Эзэний өдөр болвол би Манмин үйлчлэлийн нэгдсэн холбооны нарийн бичгийн даргын хувьд замын зохицуулгаа хийгээд ийш тийш явж тусламж дэмжлэг

хэрэгтэй хэсэг байгаа эсэхийг анзаардаг. Итгэгч нар мөргөлд ороод дараа нь хооллох үед тав тух нь алдагдаж байна уу, машины үйлчлэл хэр явагдаж байгааг хянах зэргээр үйлчилж байна.

Би ердийн үед ч итгэгч нараа нандигнан үйлчилж өгдөг И Жей руг тэргүүн пасторын дүр төрхөөр дамжуулан нүдэнд харагдахгүй Эзэний хайрыг мэдрэсэн юм.

Тэгээд би төдийгүй Манмин үйлчлэлийн нэгдсэн холбооны бүх гишүүд "Бидний Эзэн байсан бол үүнийг яах байсан бол? Хоньчин минь байсан бол юу гэх бол" гэж үргэлж сэтгэлдээ тунгааж Бурхан Аавын өмнө итгэл болон хайраар үүргээ гүйцэтгэн маш баяртайгаар үйлчилдэг.

Манмин үйлчлэлийн холбоонд хэн нэгэн нь албадлагаар орж үйлчлэх бус өөрсдөө Бурханы ивээлд Эзэний ивээлд талархан сайн дураараа цуглаж бүх гишүүд маань үйлчилье гэсэн итгэмжтэй зүтгэж байна.

Ингээд бүх үйлчлэлээ дуусаад Эзэний өдрийн орой шөнө болсон хойно гэрлүгээ харьж явахад "Энэ долоо хоног сайхан өнгөрлөө" гэсэн бодол орж ирэн, энэ л бодол намайг аз жаргалтай болгодог.

Юу юунаас илүү энэ дэлхий ертөнц бүх зүйл биш, хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалим руу хандсан тэмүүлэл байдаг учир бид энэ мэт аз жаргалтай амьдардаг.

Бүх гэр бүлээрээр үйлчилж тэнгэрийн орны бялхалаар

амьдрах тул эрүүл мэндийн ерөөлөөр дүүрэн байна

Миний хувьд хийх л ёстойгоо хийсэн боловч тэргүүн шагнал авна гэдэг нь надад жаахан эвгүй байсан. Надаас илүү харагдахгүй газар илүү хичээнгүйлэн үйлчилж хүмүүс байгаа ч би тэднийг төлөөлөн авлаа гэж бодож байна. Цаашид улам илүү Эзэний ивээлийг сэтгэлдээ улаам шингээн илүү эрч хүчтэй, зүтгэх болно гэж шийдсэн юм.

Өнгөрсөн 27-н жилийн турш манай гэр бүлийнхэн нэг удаа эмнэлэг явж үзээгүй, эм уух ч шаардлагагүй үргэлж эрүүл саруул амьдарсаар ирсэн юм. Би үйлчлэлээр, эхнэр (Юүн Ёон жа номлогч) Эзэний боолоор, охин И Сан ми урлагын багийн харьяа Кристалл дууны багт үйлчилж байна. Ялангуяа эхнэрийн хариуцсан Хятадын 2-р бүлэг сэргэж, хамтдаа тэргүүн шагнал (шилдэг бүлгийн ахлагч)-р шалгарч баяр дээр баяр нэмсэн юм.

Хайрын Бурхан манай ажил ахуйг дутагдах зүйлгүй хангаж өгсөөр байгаа юм. Юунаас ч илүү бүх гэр бүлээрээ Шинэ Иерусалимын тэмүүлэл дотор амьдрах ерөөл өгсөн Бурхан Аавдаа бүхий талархал ба алдрыг өргөө.



“Би дөлгөөхөн болж өөрчлөгдсөнөөр ерөөл дүүрэн байна.”

Би хорин настайгаасаа сүмд явсан ч библийг сайн ойлгож чадахгүй, мэдмээр байгаа зүйл маш их байлаа. Тэгтэл 2014оны 12-р сард гудамжинд сайн мэдээ тарааж байсан хүнээр дамжуулан Манмин төв сүм рүү ирж, Эхлэл номын тайлбар, Илчлэлт номын тайлбар, зэрэг И Жей руг тэргүүн пасторын сургаалийг татаж аваад сонсоход ямар нэгэн байдлаар татагдаж эхэлсэн юм. 3н сарын турш тасралтгүй сонссоор би өөрийн мэдэлгүй залбирмаар санагдаж Даниел залбирлын цагт оролцож, аравны нэгээ өргөж эхлэсэн юм.

Тэгж тэргүүн пасторын сургаалийг 1жил орчим сонссоор байтал “Аан итгэлийн амьдрал ийм байдаг байхнээ. Би өөрийн төлөө биш бусдын эрх ашгийн төлөө амьдрах ёстой юм байна” гэж ухаарсан юм. Сүнс сэтгэл биеэр бүтсэн хүний уг шинж чанарын тухай ойлголтой болж, тэгээд уур, сэтгэл тавгүйтэх зэрэг би гэх зүйлээ хаяж өөрчлөгдөж эхлэсэн юм. Ялангуяа тэргүүн пасторын залбирлаар эрх мэдэлт хүч илрэн гарч, энэ агуу хүч Бурханых (Дуулал 62:11) гэдгийг ухаарч маш их талархсан юм.

Тэгж байгаад 2017онд эгчтэй хамт амьдардаг ээж (Ким Хён сон сүмд үйлчлэгч, 84нас) манай гэрт амьдрахаар болсон юм. Би ятгаж үзэхэд ээж минь за гэх боловч нэг дургүй байгаа нь илт байлаа. Тэгэх болсон шалтгаан нь би Манмин төв сүмд ирэхээс өмнө би үргэлж миний л зөв гэж дайрч, хэний ч үгийг сонсдоггүй, маш огцом ааштай бөгөөд дүрсхийн уурлаж чангаар хашгиран загнаж маргалддаг бас байнга шахуу архи,

тамхи, мөрийтэй тоглоом зэрэг хамаг л болохгүй зүйл маш их учраас юм.

Тэгтэл манай гэрт ирсэн ээж маань намайг огт өөр хүн болсонд үнэхээр их гайхаж байлаа. “Зан ааш байтугай царай төрх нь өөрчлөгджээ.” “Чан хи яг л дөлгөөн хонь мэт болчиж” гээд намайг дагаад сүмд ирсэн юм.

Зөвхөн энэ ч биш нодний оны сүүлээр ээж маань гэрийн урд талын шатнаас унаад баруун хөлөө маш хүнд бэртээсэн ба түүнээс болж нэг сарын турш их зовиуртай байсан юм. “2019-2020оны шинэ оноо угтах мөргөл” И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-аар И Сү жин пастор нийтэд нь залбирч өгөхөд өвчин хөндүүр төгс арилж, баруун хөл дээр явдаг болсон юм.

Мөн хэдэн 10н жилийн турш өвдгөөр зовиурлаж, нугалж чадахгүй байсан ч Хуан Гым ран тэргүүн удирдагч гар алчуураар залдирч өгөхөд хөндүүр нь арилж өвдөгөө нугалдаг болсон юм. Халлеллүя!

Хүүгийнхээ өөрчлөгдсөн төрхийг хараад эрх мэдэлт хүчийг мэдэрсэн ээж маань сүүлийн үед маш баяр хөөртэй байна. Үүнийг хараад эгч маань ч манай сүмд ирж хамт явдаг болсон юм.

Өмнө нь “Яагаад би л ингэж зовох ёстой юм” гэж байсан бол “Амьдрал ийм аз жаргалтай юм уу” гэж өөрөө гайхах хэмжээнд хүрсэн юм. Энэ бүх зүйл амийн сургаал ба Эзэний л ивээл юм. Одоо илүү гүнзгий яс маханд тулгал өөрчлөгдөхийг хүсэх тэмүүлэл өгч, цаг мөч бүр ивээл дотор амьдруулж өгсөн сайн Бурхандаа бүх талархал ба алдрыг өргөө.



И Чан хи сүмд үйлчлэгч (52нас, Хятад 3-р бүлэг)

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан: power3712@gmail.com

“ДОХ-ын халдвар авч төрсөн хүү минь эдгэрсэн юм”

Акилиес Ширивастаб итгэгч
(30нас, Энэтхэг, Утар Прадеш муж)



2016оны нэгэн өдөр хамаатан маань авто осолд цус сэлбэх шаардлагатай байна гээд ижил цусны бүлэгтэй надаас цусны шинжилгээ авсан юм. Тэгээд ДОХ-н халдвар авсан юм. Эмч энэ талаар надад хэлэхэд би маш их айж сандарч “Би ямар буруу юм хийсэн юм бэ?” гэсэн юм. Тэгтэл эмч тариурын зүүнээс халдвар авсан байж болно гэж л хэлсэн юм.

Би тэр үед өөрийн ухаангүй мэт болж, эмчийн үгэнд огт итгэхгүй байлаа. Тэгээд 2017онд төрсөн манай хүү маань мөн л ДОХ-н вирус халдаж төрсөн нь тогтоогдов. Тэнгэр газар нурах мэт үнэнтэй нийцэхээс өөр аргагүй болсон юм.

Бид ДОХ өвчнөөсөө эдгэрэхийн төлөө хичээж байхад сайн мэдээ сонсож, юутуб ‘GCNTV HINDI’-р И Жей руг тэргүүн пасторын өвчний төлөөх залбирлын талаар олж мэдэж, түүний дараагаас ‘Загалмайн үг’ сургаалиар дамжуулан Эзэний тухай ихийг мэдэж маш их ивээл авсан юм.

Тэгтэл 2019оны 2-р сар ой таван

сартай хүүгийн минь баруун хацар дээр цахлай гэх арьсны тууралт өвчин гарч, 7хоногийн турш зовиурлан хүүгээ харж миний хувьд яаж ч чадахгүй байлаа. Тэгж байхад 2-р сарын 22нд Манмин төв сүмд эдгэрлийн цуглаантай гэсэнд ‘Энэ удаад заавал хүүгийнхээ өвчнийг эдгээлгэе’ чин сэтгэлээсээ ‘GCNTV HINDI’ сувгаар цуглаанд оролцож, И Сү жин пастор гар алчуур (Үйлс 19:11-12)-аар хийсэн залбирлыг авсан юм.

Тэгсэн гайхамшигтай нь яг тэр өдөртөө хүүгийн арьсны өвчин төгс эдгэрсэн юм. Үүнээс болж итгэлтэй болсон би ‘GCNTV HINDI’-р Манмин төв сүмийн мөргөлд оролцож, Бурханаас эдгэрэл авахын төлөө эм уухаа больсон юм.

Цаашлаад 6-р сард ДОХ-н шинжилгээнд хүү минь сөрөг гарснаар жинхэнэ гайхамшиг болсон юм.

Эцэг эхээсээ болоод ДОХ той төрсөн хүү минь бүх насаараа эм ууж амьдрах байсанд маш харамсаж байсан ч Бурханы гайхамшигт хүч чадлаар

эдгэрч, яг зүүдэлж буй мэт байна.

Бид улам их итгэлээр өсч, тэргүүн пасторын сургаалийг хүсэн тэмүүлж, өдөр бүр өвчний төлөө залбирал авч, байна. Эмээ уухгүй байсан ч өмнөхөөсөө ч илүү эрч хүчтэй болж, өвчний шинж тэмдэг ч гарч илрэхгүй болсон юм.

Цаашид ч төгс эдгэрээд Бурхандаа алдрыг өргөхийг хүсч байгаа бөгөөд хүүгийн минь эдгэршгүй өвчин төгс эдгээж өгсөн Бурхандаа талархал алдрыг өргөе. И Жей руг тэргүүн пастортаа талархал илэрхийлье.

Хүүгийн шинжилгээний тэмдэглэл



Залбирал авахын өмнө: Хүү төрөөд 2017оны 12-р сард авсан ДОХ-н шинжилгээний хариу эерэг гарсан нь.

Залбирал авсаны дараа: 2019оны 6-р сард авсан ДОХ-н шинжилгээний хариу сөрөг гарсан нь.